



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 4/58

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн "Жагсаалт батлах тухай" 336 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-ын 8.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 221 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 04 дүгээр хуралдааны шийдвэрийн дагуу аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцдөд 30 тонн багсармал тэжээлийг 18,000,000 (арван найман сая) төгрөгөөр Зүлэгт агро ХХК-иас худалдан авахыг зөвшөөрсүгэй

2. Тэжээл нийлүүлсэн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, тэжээлийн чанар, савлагаа, гарал үүсэл зэрэгт хяналт тавьж, гэрээ байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (С.Цэдэнбалжир)-д даалгасугай.

3. Дээрх зардал болох 18,000,000 (арван найман сая) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



6222 11 0121

D:My Doc. Zahiramj. Zasag darga